



2018 оны 02 дугаар сарын 22
№08/1013/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Хувь хүний орлогын
албан татварын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Төрийн аудитын
байгууллагын албан хаагчид
олгох нэмэгдлийн хэмжээг
тогтоох тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Журам шинэчлэн
батлах тухай**

ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

83.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	242
84.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	243
85.	Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	244
86.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	244
87.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	245
88.	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	248
89.	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	249

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

90.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 17	249
91.	Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай	Дугаар 18	250
92.	Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 02 дугаар дүгнэлтийн тухай	Дугаар 19	250



93.	Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 20	251
94.	Төрийн аудитын байгууллагын албан хаагчид олгох нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай	Дугаар 21	252
95.	Тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 22	252
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
96.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 05	253

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг:

“23.1.Энэ хуулийн 17 дугаар зүйл, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна.”

2/24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг:

“24.1.Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараахь хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ:

Д/д	Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хөнгөлөлтийн хэмжээ /төгрөгөөр/	
		2018 он	2019 он ба түүнээс хойш
1	0-6 000 000 хүртэл	160 000	240 000
2	6 000 000-12 000 000 хүртэл	140 000	220 000
3	12 000 000-18 000 000 хүртэл	120 000	200 000
4	18 000 000-24 000 000 хүртэл	100 000	180 000
5	24 000 000-30 000 000 хүртэл	80 000	160 000
6	30 000 000-36 000 000 хүртэл	60 000	140 000
7	36 000 000 ба түүнээс дээш	-	-



3/26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалт:

“26.1.1.энэ хуулийн 11 дүгээр зүйл, 15.1-д заасан орлогын дүнд 23.1-д заасан хувиар, 14.1.1-д заасан орлогын дүнд 23.2.1-д заасан хувиар, 8.1.6, 8.1.7-д заасан орлогын дүнд 23.2.2-т заасан хувиар, 8.1.8-д заасан орлогын дүнд 23.2.3-т заасан хувиар, 12.2, 13.1.2, 13.1.3, 13.1.4-т заасан орлогын дүнд 23.2.4-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;”

2 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.4 дэх заалтын “, 22.1.4” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “60 нас хүрсэн” гэсний дараа “эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “55” гэснийг “50” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтын “55 нас хүрсэн бол” гэснийг “50 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр” гэж, мөн хэсгийн 2 дахь заалтын “эрэгтэй 55 нас” гэснийг “эрэгтэй 50 нас” гэж, “эмэгтэй 50 нас хүрсэн бол” гэснийг “эмэгтэй 45 нас хүрсэн бол тус тус өөрийн хүсэлтээр” гэж, 22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн “5” гэснийг “7” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “таван” гэснийг “долоон” гэж, 2 дахь заалтын “таван” гэснийг “долоон” гэж, “60-д хуваана” гэснийг “84-д хуваана.” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “заасны дагуу” гэсний дараа “бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын “65” гэснийг “эрэгтэй 60, эмэгтэй 55” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд доор дурдсан агуулгатай 5¹, 6¹, 6² дугаар зүйл тус тус нэмсүгэй:

1/5¹ дүгээр зүйл:

“5¹ дүгээр зүйл.Малчинд тэтгэвэр тогтоох болон тэтгэврийн насыг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах журмыг Засгийн газар батална.”

2/6¹ дүгээр зүйл:

“6¹ дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан өндөр насны тэтгэврийг өөрийн хүсэлтээр эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 насандаа тогтоолох даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацааг 2038 он хүртэл жил бүр 3 сараар нэмэгдүүлнэ.”

3/6² дугаар зүйл:

“6² дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дараалсан хугацаа 2019 онд 6 жил, 2020 онд 7 жил, өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийн хуваагдах сарын тоо 2019 онд 72 сар, 2020 онд 84 сар байна.”



2 дугаар зүйл.1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2 дугаар зүйл.Өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны болзлыг доор дурдсанаар тогтооно:

1/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас:

Эрэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоох нас
1957 ба түүнээс өмнө	60 нас
1958	60 нас 3 сар
1959	60 нас 6 сар
1960	60 нас 9 сар
1961	61 нас
1962	61 нас 3 сар
1963	61 нас 6 сар
1964	61 нас 9 сар
1965	62 нас
1966	62 нас 3 сар
1967	62 нас 6 сар
1968	62 нас 9 сар
1969	63 нас
1970	63 нас 3 сар
1971	63 нас 6 сар
1972	63 нас 9 сар
1973	64 нас
1974	64 нас 3 сар
1975	64 нас 6 сар
1976	64 нас 9 сар
1977 ба түүнээс хойш	65 нас



2/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан эмэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолох нас:

Эмэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоох нас
1962 ба түүнээс өмнө	55 нас
1963	55 нас 3 сар
1964	55 нас 6 сар
1965	55 нас 9 сар
1966	56 нас
1967	56 нас 3 сар
1968	56 нас 6 сар
1969	56 нас 9 сар
1970	57 нас
1971	57 нас 3 сар
1972	57 нас 6 сар
1973	57 нас 9 сар
1974	58 нас
1975	58 нас 3 сар
1976	58 нас 6 сар
1977	58 нас 9 сар
1978	59 нас
1979	59 нас 3 сар
1980	59 нас 6 сар
1981	59 нас 9 сар
1982	60 нас
1983	60 нас 3 сар
1984	60 нас 6 сар
1985	60 нас 9 сар
1986	61 нас
1987	61 нас 3 сар
1988	61 нас 6 сар
1989	61 нас 9 сар
1990	62 нас
1991	62 нас 3 сар



1992	62 нас 6 сар
1993	62 нас 9 сар
1994	63 нас
1995	63 нас 3 сар
1996	63 нас 6 сар
1997	63 нас 9 сар
1998	64 нас
1999	64 нас 3 сар
2000	64 нас 6 сар
2001	64 нас 9 сар
2002 ба түүнээс хойш	65 нас

3 дугаар зүйл.1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “дараалсан 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д” гэснийг “дараалсан 7 жилийн цалин хөлсний нийлбэрийг 84-т” гэж, “5 хүртэл жил” гэснийг “7 хүртэл жил” гэж тус тус өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтооход баримтлах сарын цалин хөлсний дараалсан жил нь 2019 онд 6 жил, 2020 онд 7 жил, цалин хөлсний нийлбэрийн хуваагдах сарын тоо 2019 онд 72 сар, 2020 онд 84 сар байна.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор Улсын Их Хурал болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан 2018 оны улс, орон нутгийн төсвийн орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрийг батлагдсан хэмжээнээс нэмэгдүүлэх боломжит бүх арга хэмжээг авч, улс, орон нутгийн төсвийн хэвийн үйл ажиллагааг ханган



ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т, аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

2.Энэ тогтоолыг 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар
хот

**Үндсэн хуулийн цэцийн 2018 оны
01 дүгээр дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр баталсан Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтад “дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох,” гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

**Үндсэн хуулийн цэцийн 2018 оны
02 дугаар дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.“Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлээр нэмэлт, өөрчлөлт оруулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалтад “хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийн талаар холбогдох байгууллагаас тодорхойлолт, лавлагаа авах.”, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэгт “... Энэ хуулийн 67.1.5-д заасан тодорхойлолт, лавлагааг үндэслэн төлбөр гаргуулах хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийг тодорхой тусган, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Л.Болдыг Хүний эрхийн дэд хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

Төрийн аудитын байгууллагын албан хаагчид олгох нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн аудитын байгууллагын албан хаагчид олгох нэмэгдлийн хэмжээг доор дурдсанаар тогтоосугай:

- 1/төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5-25 хувиар;
- 2/албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 30 хүртэл хувиар;
- 3/мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 35 хүртэл хувиар.

2.Төрийн аудитын байгууллагын албан хаагчид нэмэгдэл олгох журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, энэ тогтоолын 1-д заасан нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингаас тооцож 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг Монгол Улсын Ерөнхий аудитор /Д.Хүрэлбаатар/-т зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 22

Улаанбаатар
хот

Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсад 2018-2020 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 02/01 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга /А.Гансүх/-д даалгасугай.

3. Энэхүү зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Журам батлах тухай” 2010 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 266 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**



Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн
05 дугаар зарлигийн хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙГ МЭДЭЭЛЛЭЭР
ХАНГАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс /цаашид “Зөвлөл” гэнэ/ үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах, дүгнэлт гаргах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, уялдуулан зохицуулах, шийдвэрлэх чиглэл, даалгавар өгөх, шаардлага тавих, хэрэгжилтэд хяналт тавихад шаардлагатай мэдээллээр төрийн холбогдох байгууллагууд Зөвлөлийг хангахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Зөвлөлийг мэдээллээр хангах үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү журмын дагуу зохион байгуулна.

1.3 Энэхүү журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрдөнө.

Хоёр. Нэр томьёо

2.1 Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.1.1 “Яаралтай мэдээ” гэж хугацаа хожимдвол үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд хохирол учруулахуйц үйл явдлын тухай мэдээ, Зөвлөлөөс албан хэрэгцээнд нэн даруй ирүүлэхийг шаардсан мэдээ;

2.1.2 “Шуурхай мэдээ” гэж тухайн үед болсон үйл явдал, хэргийн талаарх мэдээлэл;

2.1.3 “Танилцуулах мэдээ” гэж үйл явдлын товч танилцуулга, тодорхой дүгнэлт, санал бүхий мэдээлэл;

2.1.4 “Танилцуулах тойм мэдээ” гэж тодорхой хугацааны үйл явдлыг тоймлож, түүний явц, өрнөлд үнэлэлт, дүгнэлт өгсөн, цаашид авах арга хэмжээний саналыг тусгасан мэдээ;

2.1.5 “Тайлан мэдээ” гэж үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг тухайн салбар, байгууллагын хүрээнд хэрхэн зохион байгуулж, хэрэгжүүлсэн, гарсан үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын тухай тайлагнасан мэдээ;

2.1.6 “Гадаад мэдээ” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал хэрхэн хангагдаж байгаа талаар мэдээ;

2.1.7 “Дотоод мэдээ” гэж Монгол Улсын үндсэн хуульт байгуулал, хууль дээдлэх ёс, төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдэл, эдийн засгийн аюулгүй байдал, улс төр, иргэний нийгмийн байгуулал, чөлөөт хэвлэл мэдээлэл, нийгмийн дэг журам, тогтвортой байдал, хүний эрх, эрх чөлөө хэрхэн хангагдаж байгаа талаар мэдээ;

2.1.8 “Төрийн байгууллага” гэж Төрийн хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх эрх мэдлийн бүтцийн, төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны төв болон захиргааны байгууллага;

2.1.9 “Төрийн албан тушаалтан” гэж энэ журмын 2.1.8-д заасан байгууллагын удирдах болон хууль тогтоомжийн дагуу асуудал хариуцсан ажилтан;

2.1.10 “Аж ахуйн нэгж” гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар,



тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд;

2.1.11 “Иргэн” гэж Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;

2.1.12 “төрийн бус байгууллага” гэж иргэд нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг нийгэмд болон гишүүддээ үйлчилдэг ашгийн төлөө бус байгууллага (улс төрийн нам, шашны байгууллага орно).

Гурав. Зөвлөлийг мэдээллээр хангах тогтолцоо

3.1 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн холбогдох байгууллагууд Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан асуудлаар төрийн байгууллагууд Зөвлөлийг мэдээллээр байнга хангана.

3.2 Байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээ, түүний үр дүнг тогтоосон хугацаанд хариу мэдээлэх үүрэгтэй.

3.3 Зөвлөл нь үндэсний язгуур ашиг сонирхол, аюулгүй байдалтай холбоотой гэж үзсэн бүхий л асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс шаардлагатай (нууц мэдээлэл мөн хамаарна) мэдээллийг гаргуулан авна.

3.4 Мэдээллийг энэ журмын дагуу Зөвлөлийн нарийн бичгийн дарга болон Ажлын албанд хүргүүлнэ. Зөвлөлийн гишүүдийн нэр дээр хаягласан мэдээллийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авч, Зөвлөлийн гишүүдэд уламжилна.

3.5 Зөвлөлийн Тэргүүн, гишүүдээс өгсөн чиглэлийг үндэслэн мэдээллийн дагуу авах арга хэмжээг Зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын алба хариуцна.

3.6 Ажлын албаны дарга болон Ажлын албаны нэр дээр хүргүүлсэн мэдээллийг Зөвлөлийн нарийн бичгийн даргад танилцуулж чиглэл авна.

3.7 Аймаг, нийслэл нь аймаг, нийслэлийн Засаг даргын ахалсан Зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын Ажлын хэсэгтэй байна.

3.7.1 Ажлын хэсэг дараах бүрэлдэхүүнтэй байна.

- Аймаг, нийслэлийн Цагдаагийн газар, хэлтсийн дарга;
- Тагнуулын газрын дарга;
- Цэргийн штабын дарга;
- Онцгой байдлын газрын дарга;
- Татварын газар, хэлтсийн дарга;
- Статистикийн газар, хэлтсийн дарга;
- Байгаль орчны газрын дарга.

Дөрөв. Мэдээллийн ангилал, хугацаа

4.1 Зөвлөлд ирүүлэх мэдээлэл нь шинж чанараасаа хамааран яаралтай мэдээ, шуурхай мэдээ, танилцуулах мэдээ, танилцуулах тойм мэдээ, тайлан мэдээ, илтгэл, нууц мэдээ (нууцын зэрэглэлээр нь ангилсан) гэсэн ангилалтай байна.

4.2 Мэдээллийг эх үүсвэрээр нь гадаад, дотоод мэдээ гэж ангилна.

4.3 Яаралтай мэдээг тухайн үйл явдал болсон даруйд цаг алдалгүй Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-д заасны дагуу мэдээлж, Зөвлөлийн нарийн бичгийн даргад танилцуулна.



4.4 Үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа тухай илтгэлийг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд хагас жилд нэг удаа, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд жил бүр Зөвлөлийн нарийн бичгийн даргын нэр дээр ирүүлнэ.

4.5 Долоо хоногийн мэдээг тухайн долоо хоногийн баасан гаригт, сарын мэдээг сар бүрийн сарын сүүлийн долоо хоногт, улирлын мэдээг улирал бүрийн сүүлийн долоо хоногт, хагас жилийн мэдээг 6 дугаар сарын сүүлийн долоо хоногт, жилийн эцсийн мэдээг тухайн жилийн 12 дугаар сарын 15-ны дотор багтаан Зөвлөлийн нарийн бичгийн даргын нэр дээр ирүүлнэ.

4.6 Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд, энэхүү журмын хавсралтад заасан төрийн байгууллагууд, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар хоногт болсон онцгой үйл явдал, цаг үеийн нөхцөл байдлын тухай шуурхай мэдээг өглөө бүр 8 цагаас өмнө Зөвлөлийн ажлын албанд ирүүлсэн байна.

Тав. Зөвлөлд мэдээлэл ирүүлэх

5.1 Зөвлөлд ирүүлэх төрийн болон албаны нууц мэдээллийг хүлээн авч боловсруулах, дамжуулахдаа Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ыг мөрдөнө.

5.2 Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-д зааснаар мэдээний нууцын зэрэглэлийг илгээгч байгууллага шийдвэрлэнэ.

5.3 Нууцын зэрэглэлтэй мэдээллийг зөвхөн Зөвлөлийн нарийн бичгийн даргад холбогдох журмын дагуу хүргүүлнэ.

5.4 Төрийн байгууллагууд энэхүү журмын хавсралтад заасан мэдээллийг Зөвлөлийн ажлын албанд бичгээр ирүүлнэ. Мэдээллийг эрх

бүхий албан тушаалтны гарын үсэг бүхий албан тоотоор шуудангаар, биечлэн эсвэл цахим шуудангаар хүргүүлнэ.

5.5 Цаасаар хүргүүлж байгаа мэдээллийг цахим хэлбэрээр (flash, CD гэх мэт) хавсаргасан байна. Ингэхдээ мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээг авсан байна.

5.6 Мэдээлэл нь Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан үндсэн зарчимд тулгуурласан, бодит мэдээлэлд үндэслэсэн, цэгцтэй, товч байна. Энэхүү журмын хавсралтад заасан төрийн байгууллага, албан тушаалтан нь заасан хугацаанд мэдээллийг Зөвлөлийн ажлын албанд ирүүлэх үүрэгтэй.

5.7 Төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтан Зөвлөлийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үйл ажиллагааг хариуцсан ажилтанг томилж, түүний гүйцэтгэх үүргийг ажил үүргийн хуваарьт нарийвчлан тусгана;

5.8 Зөвлөлд ирүүлэх мэдээллийг Төрийн тусгай шуудангаар эсвэл тусгай томилсон ажилтнаар биечлэн хүргүүлнэ.

5.9 Төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтан мэдээллийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга, чиглэл хариуцсан референт, мэдээлэл, дүн шинжилгээний төвийн шинжээч нарт Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-д заасны дагуу дамжуулж, энэ тухай албан бичгээр баримтжуулна.

5.10 Зөвлөлийг мэдээллээр хангах үүргийн дагуу Зөвлөлийн нарийн бичгийн даргын албан ёсоор бичгээр шаардсан мэдээллийг шаардсан хэлбэрээр холбогдох төрийн дээд, төв байгууллага, албан тушаалтан шаардсан хугацаанд хүргүүлэх үүрэгтэй.

5.11 Энэхүү журмын хавсралтад заагаагүй мэдээ, мэдээлэл, санал, судалгааг Зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэг, чиглэлийн дагуу Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд зааснаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд ирүүлэх үүрэгтэй.



5.12 Энэхүү журмын дагуу хүлээн авсан бүх төрлийн нууц мэдээллийг зөвхөн Үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж, нууцлалыг чанд хадгална.

Зургаа. Журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага

6.1 Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Зөвлөл шаардлагатай гэж үзсэн бүхий л мэдээллийг гаргуулан авах эрхтэй бөгөөд энэхүү журмын хавсралтад заагаагүй нь түүнийг гаргаж өгөхгүй байх үндэслэл болохгүй.

6.2 Энэ журмын дагуу Зөвлөлийг мэдээллээр хангах үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтан түүнийг биелүүлэхгүй байх, удаашруулах, саатуулах, эсэргүүцэх, бодит бус ташаа мэдээлэл бэлтгэх зэрэг аливаа үйлдэл, эс үйлдэл хийхийг хориглоно.

6.3 Энэ журмын 6.2 дахь заалтыг зөрчсөн албан тушаалтныг Зөвлөлийн ажлын алба хууль хяналтын байгууллагаар шалгуулж шалтгааныг тогтоолгоно. Уг албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл нь үндэсний аюулгүй байдалд хохирол учруулсан болох нь тогтоогдвол хуулийн дагуу хариуцлага тооцон энэ тухай Зөвлөлийн гишүүдэд мэдэгдэнэ.

“Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын нэгдүгээр хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДААС ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛД ИРҮҮЛЭХ МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ, ХУГАЦАА

Д/д	Байгууллага	Мэдээлэл	Ангилал	Хугацаа
Нэг. Улсын Их Хурлын харьяа байгууллагууд				
1.	Улсын Их Хурлын Тамгын газар	УАБЗ-ийн Зөвлөмжийн хэрэгжилт УИХ-ын харьяа байгууллагын үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар авч хэрэгжүүлсэн ажлын тухай УИХ-ын судалгаа, шинжилгээний нэгжийн тайлан	Тайлан мэдээ Тайлан мэдээ Тайлан мэдээ	Улирал бүр Хагас жил тутам Тухай бүр
2.	Үндэсний аудитын газар	Хяналт шалгалтаар илрүүлсэн, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд шууд болон шууд бусаар ноцтой аюул, их хэмжээний хор хохирол учруулж байгаа, учруулж болзошгүй эрсдэлт үйл явдлын тухай Нийгэм, эдийн засгийн аюулгүй байдал хэрхэн хангагдаж буй талаар мэдээ, мэдээлэл, судалгаа	Танилцуулах мэдээ Танилцуулах тойм мэдээ	Тухай бүр Жил бүр
3.	Үндэсний статистикийн хороо	Хүнчний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт Хорооноос гаргасан сар, жилийн тоон мэдээ, мэдээлэл, тайлан	Танилцуулах тойм мэдээ Танилцуулах тойм мэдээ	Улирал бүр Сар бүр
4.	Монгол банк	Банк, санхүүгийн салбарын үйл ажиллагаа, тулгамдаж буй эрсдэл, төрийн мөнгөний бодлогод сөрөг нөлөөтэй хүчин зүйлсийн тухай Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн хэрэгжилт	Танилцуулах мэдээ Танилцуулах мэдээ	Улирал бүр Улирал бүр

		<p>Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт, банкны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын тухай</p> <p>Монгол Улсын гадаад валютын нөөцийн тухай (импортын хэрэгцээг хангах хугацааг хоногоор гаргах)</p> <p>Банкны үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилт, санхүүгийн тайлан</p> <p>Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, учирч буй эрсдлийн талаарх судалгаа</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p>	<p>Улирал бүр</p> <p>Улирал бүр</p> <p>Улирал бүр</p> <p>Улирал бүр</p>
5.	Санхүүгийн зохицуулах хороо	<p>Даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаа, санхүүгийн тухай мэдээлэл, судалгаа</p> <p>Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсэн тухай</p>	<p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p>	<p>Улирал бүр</p> <p>Тухай бүр</p>
6.	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс	<p>Хүний эрхийн асуудлаар судалгаа явуулж, шаардлагатай мэдээллээр хангах</p> <p>Иргэдийн эрх, эрх чөлөөний байдлын талаарх хийсэн ажлын тайлан</p>	<p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Улирал бүр</p> <p>Жил бүр</p>
7.	Авлигатай тэмцэх газар	<p>Авлигатай тэмцэх газарт хөрөнгө, орлогын мэдүүлгээ өгдөг төрийн албан тушаалтны үйлдсэн авлигын гэмт хэргийн тухай</p> <p>Авлигын гэмт хэргийн илрүүлэлтийн тухай мэдээ</p> <p>Төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдэлт, явцын тухай</p>	<p>Шуурхай мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Хагас жил тутам</p> <p>Жил бүр</p>

8.	Төрийн албаны зөвлөл	Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо, тайлан мэдээ, судалгаа Төрийн албан хаагчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэргэсэн тухай	Танилцуулах тойм мэдээ Танилцуулах тойм мэдээ	Жил бүр Хагас жил тутам
Хоёр: Засгийн газрын харьяа байгууллагууд				
9.	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	<p>Зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлтийн талаар</p> <p>Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт</p> <p>Засгийн газрын үйл ажиллагааны үр дүнгийн мэдээ</p> <p>Засгийн газрын харьяа байгууллагуудын Үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын мэдээ, мэдээлэл</p> <p>Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа иргэддээ эх орондоо эргэн ирж ажиллаж амьдрах таатай нөхцөл, боломжийг бүрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны тухай</p> <p>Газар хөдөлөлтийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж буй ажлын явц, үр дүнгийн талаар</p> <p>Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, явцын тухай мэдээ, тайлан</p> <p>Засгийн газрын тогтоолоор баталсан "Үндэсний зөвлөл"-үүдийн төлөвлөгөө, үйл ажиллагааны тайлан</p>	<p>Тайлан мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Тайлан мэдээ</p> <p>Тайлан мэдээ</p> <p>Тайлан мэдээ</p> <p>Тайлан мэдээ</p> <p>Тайлан мэдээ</p> <p>Тайлан мэдээ</p>	<p>Хагас жил тутам Тухай бүр</p> <p>Жил бүр</p> <p>Жил бүр</p> <p>Жил бүр</p> <p>Жил бүр</p> <p>Жил бүр</p> <p>Хагас жил тутам Хагас жил тутам</p>
10.	Тангуулын ерөнхий газар	Үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулж болзошгүй нөхцөл байдал, хүчин зүйлс, тэдгээрээс сэрэмжлүүлэх арга хэмжээний санал	Яаралтай мэдээ Шуурхай мэдээ	Тухай бүр



Улирал бүр Улирал бүр	Танилцуулах тойм мэдээ Танилцуулах тойм мэдээ	Тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажлын товч тайлан Тагнуулын байгууллагын харьяаллын хэргийг илрүүлэн шийдвэрлэсэн тухай	
Тухай бүр Жил бүр	Шуурхай мэдээ Танилцуулах мэдээ	Онц чухал дэд бүтэцтэй байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын тухай	
Жил бүр	Танилцуулах мэдээ	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах бодлого, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн тухай	
Тухай бүр Улирал бүр	Шуурхай мэдээ Танилцуулах мэдээ	Мэдээллийн аюулгүй байдлын нөхцөл байдал, энэ талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай	
Тухай бүр Улирал бүр	Шуурхай мэдээ Танилцуулах мэдээ	Мэдээллийн аюулгүй байдлын зөрчил, цахим халдлагын талаар	
Тухай бүр Улирал бүр	Шуурхай мэдээ Танилцуулах мэдээ	Төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын тухай	
Тухай бүр Улирал бүр	Шуурхай мэдээ Танилцуулах мэдээ	Төрийн байгууллагуудын сүлжээний аюулгүй байдлын тухай	
Улирал бүр	Танилцуулах тойм мэдээ	Терроризмтой тэмцэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын явц, үр дүнгийн тухай	
Тухай бүр Сар бүр	Шуурхай мэдээ Танилцуулах мэдээ	Бүс нутгийн болон Монгол Улсын цэргийн баг үүрэг гүйцэтгэж буй орнуудын цэрэг улс төрийн байдлын тухай	
Тухай бүр Хагас жил тугам	Шуурхай мэдээ Танилцуулах тойм мэдээ	Хөрш орнуудын цэргийн бодлогод гарч буй өөрчлөлт, зэвсэгт хүчний чадавх, байрлал, зориулалт, зэвсэглэл, сургууль, хөдөлгөөний тухай	

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал	Төрийн өмчийн эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Төрийн өмчийн эд хөрөнгийн хувьчлалын тухай тайлан Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны тухай тайлан Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн гадаад, дотоодод гаргасан үнэт цаас, арилжааны гэрээ, хэлэлцээрийн тухай Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн бэлтгэн нийлүүлэх, туслан гүйцэтгэх үйл ажиллагаанд оролцож байгаа үндэсний жижиг, дунд үйлдвэрүүдийн тухай	Танилцуулах мэдээ	Тухай бүр
11.	Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Олон улсын байгууллагуудаас мэдээллийн салбарт хэрэгжүүлж буй төслийн явцын тухай Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө, хөтөлбөр, хийсэн ажлын талаар Мэдээлэл, харилцаа холбооны салбарын томоохон төслүүдийн бэлтгэн нийлүүлэх, туслан гүйцэтгэх үйл ажиллагаанд оролцож байгаа үндэсний жижиг, дунд үйлдвэрүүдийн тухай Төрийн байгууллагаас мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн тухай	Танилцуулах тойм мэдээ Танилцуулах мэдээ Танилцуулах тойм мэдээ Танилцуулах мэдээ	Хагас жил тутам Улирал бүр Хагас жил тутам Жил бүр
13.	Харилцаа холбооны зохицуулах хороо	Харилцаа холбооны зохицуулалтын талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн тухай Мэдээллийн салбарт үйл ажиллагаа явуулах эрх авсан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн тухай Тусгай зөвшөөрөл, стандарт, баталгаажуулалтын тухай	Шуурхай мэдээ Танилцуулах мэдээ Танилцуулах мэдээ Тайлан мэдээ Танилцуулах тойм мэдээ	Тухай бүр Улирал бүр Тухай бүр Жил бүр Жил бүр

	<p>Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага</p>	<p>Монгол Улсын хөгжлийн цогц бодлого, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбар, дэд бүтцийн зохистой харьцааны талаар Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын төлөвлөлт болон хэрэгжилтийн талаар Хөрөнгө оруулалтын статистик мэдээ, мэдээлэл Концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын хэрэгжилтийн тухай</p>	<p>Танилцуулах тойм мэдээ Танилцуулах тойм мэдээ Танилцуулах тойм мэдээ Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Улирал бүр Улирал бүр Улирал бүр Улирал бүр</p>
14.		<p>Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн хайгуул ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаар Цөмийн эрчим хүчний үйлдвэрлэл, цөмийн материалыг боловсруулах үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн талаар Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн нөөц, үнэ, зах зээлийн судалгаа</p>	<p>Танилцуулах тойм мэдээ Танилцуулах тойм мэдээ Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Сар бүр Сар бүр Хагас жил тугам</p>
15.	<p>Цөмийн энергийн комисс</p>	<p>Цацраг идэвхт бодисын хадгалалт, ашиглалт, цацрагийн хамгаалалтын талаар Цацраг идэвхт болон цацрагийн үүсүүртэй хөг хаягдлийн хадгалалт, булшлалт, устгалтын талаар Цөмийн энергийн салбарт төрөөс баримтлах бодлого, цөмийн энергийн хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудлууд</p>	<p>Танилцуулах тойм мэдээ Танилцуулах тойм мэдээ Танилцуулах тойм мэдээ</p>	<p>Сар бүр Жил бүр Хагас жил тугам</p>

16.	Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Иргэний бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, засварлах, гадаадын иргэдэд ашиглуулах гэмт хэргийн талаар Хүн амын шилжилт, хөдөлгөөний талаар Хүн амын төрөлтийн өсөлт, бууралтын тухай(аймаг, нийслэлээр) Шашны байгууллага, сүм хийд, төрийн бус байгууллагуудын тухай	Танилцуулах мэдээ Танилцуулах тойм мэдээ Танилцуулах тойм мэдээ Танилцуулах мэдээ	Хагас жил тутам Улирал бүр Жил бүр Улирал бүр
17.	Мэргэжлийн хангалтын төв байгууллага	Хяналт шалгалтын ажлын явцад илрүүлсэн, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй зөрчлийн тухай Дотоодын үйлдвэрийн болон импортийн хүнсний бүтээгдэхүүн, эм био бэлдмэл, худалдаа үйлчилгээний хяналт, лабораторийн үйл ажиллагаа, хяналт, шалгалтын тухай Химийн хортой, мансууруулах, тэсэрч дэлбэрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн импорт, үйлдвэрлэл, хадгалалт, ашиглалтын тухай Тэсэрч, дэлбэрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих хуулийн хэрэгжилтийн тухай Ашигт малтмалын хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, уурхайн талбайн нөхөн сэргээлтийн тухай Амьдрах орчны аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа тухай Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалт, үндэсний аюулгүй байдал, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд ноцтой хохирол учруулсан хэрэг зөрчлийн тухай	Танилцуулах мэдээ Шуурхай мэдээ Танилцуулах мэдээ Танилцуулах мэдээ Танилцуулах мэдээ Танилцуулах мэдээ Танилцуулах тойм мэдээ Шуурхай мэдээ	Тухай бүр Тухай бүр Хагас жил тутам Сар бүр Жил бүр Жил бүр Жил бүр Сар бүр



	<p>Эдийн засгийн томоохон төслүүдийн нэгжүүдийн бэлтгэн нийлүүлэх, туслан гүйцэтгэх үйл ажиллагаанд оролцох байгаа үндэсний жижиг, дунд үйлдвэрүүдийн тухай</p> <p>Эмийн мэдрэг чанарын үзүүлэлт, баталгаажилтад хийгдсэн хяналтын тухай</p> <p>Эрүүл мэндийн салбарын эмчилгээ, оношлогооны чанарын хяналтын үйл ажиллагааны тухай</p>	<p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ Тайлан мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Шуурхай мэдээ Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах мэдээ</p> <p>Танилцуулах тойм мэдээ</p> <p>Шуурхай мэдээ</p> <p>Тайлан мэдээ</p> <p>Тайлан мэдээ</p>	<p>Жил бүр</p> <p>Хагас жил тугам</p> <p>Тухай бүр Жил бүр</p> <p>Тухай бүр</p> <p>Тухай бүр 7 хоног тугам</p> <p>Хагас жил тугам</p> <p>Жил бүр</p> <p>Хоног тугам</p> <p>Жил бүр</p> <p>Жил бүр</p>
